



БАТЛАВ
АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

М.МӨНХӨӨ



БАТЛАВ
ОЛОЛТ АМЖИЛТ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Т.БАЯРЦЭЦЭГ

**ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН
ТОГТОЛЦООНЫ ISO 45001:2018 СТАНДАРТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ
ГЭРЭЭ**

2023 оны 12-р сарын 04 өдөр

Дугаар ... 333/113

Улаанбаатар хот

Нэг талаас “Амгалан дулааны станц” Төрийн өмчит хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал М.Мөнхөө, нөгөө талаас Ололт амжилт ХХК-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Т.Баярцэцэг /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дүгээр зүйл, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29-р зүйлийн 29.2 дахь заалт, 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Гэрээний зорилго нь захиалагчийн үйл ажиллагаанд Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежментийн тогтолцооны ISO 45001:2018 стандарт (цаашид “ХЭМАБ-ын МТ” гэх)-ыг нэвтрүүлэхэд гүйцэтгэгчээс зөвлөх үйлчилгээ үзүүлэх, гэрээнд заасан үнэ, хугацаа, нөхцөлийн дагуу гэрээт ажлыг хийж гүйцэтгэх, захиалагч тал нь гүйцэтгэсэн ажлын хөлсийг төлөхтэй холбогдон гарах харилцааг зохицуулна.
- 1.2 Энэхүү гэрээнд талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлснээр гэрээ дуусгавар болно.
- 1.3 Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

ХОЁР. ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

- 2.1 Гэрээний хугацаанд гүйцэтгэгч нь ХЭМАБ-ын менежментийн тогтолцооны зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:
 - 2.1.1 Зөвлөх үйлчилгээний “Ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулж захиалагчид танилцуулах ба энэхүү гэрээний хавсралтаар баталж, зөвлөх үйлчилгээний бүхий л үе шатад түүнийг удирдлага болгон ажиллана.
 - 2.1.2 Захиалагчийн ХЭМАБ-ын МТ-ны одоогийн түвшинг тодорхойлох, ISO 45001 стандартын зөрүүний шинжилгээ хийнэ.
 - 2.1.3 Зөрүүний шинжилгээний үр дүнг үндэслэн зөвлөх үйлчилгээний нарийвчилсан төлөвлөгөө гаргаж захиалагчтай хамтран хэрэгжүүлнэ.

Захиалагч
Гүйцэтгэгч

- 2.1.4 ХЭМАБ-ын МТ-ныг танилцуулах сургалт, дотоод аудитор бэлтгэх сургалтуудыг үе шаттайгаар зохион байгуулна.
- 2.1.5 ХЭМАБ-ын МТ-ны шаардлагуудыг хангах, холбогдох баримтжуулсан мэдээллүүдийг бий болгоход заавар, зөвлөгөө өгнө.
- 2.1.6 ХЭМАБ-ын МТ-ны баримт бичгийн бүрдүүлэлт хийх, түүнийг хянах, сайжруулах, хэрэгжүүлэх ажлыг холбогдох албан тушаалтанд зааж чиглүүлнэ.
- 2.1.7 Захиалагчийн гэрээт, туслан гүйцэтгэгч компаниудад тавигдах ХЭМАБ-ын МТ-ны хяналтын механизмыг боловсронгуй болгоход зөвлөгөө өгнө.

ГУРАВ. ЗАХИАЛАГЧЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Захиалагчийн эрх:

- 3.1.1 Гүйцэтгэгчийн ажлын чанар, төлөвлөгөөт хугацаанд гүйцэтгэж буй байдал зэрэгт хяналт тавих.
- 3.1.2 Гүйцэтгэгчийн ажлын чанар хангалтгүй тохиолдолд тухайн ажлыг чанарын өндөр түвшинд дахин гүйцэтгүүлэх.
- 3.1.3 Гүйцэтгэгч нь хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу зөрчсөнөөс учирсан хохирлыг арилгуулах.
- 3.1.4 Гүйцэтгэгчийг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах.
- 3.1.5 Гэрээт ажлын чанар, гүйцэтгэлтэй холбоотой аливаа санал, гомдлоо гүйцэтгэгчид албан ёсоор бичгээр өгч шийдвэрлүүлэх.
- 3.1.6 Гүйцэтгэгчээс, холбогдох хууль, дүрэм, журам, стандартад заасан шаардлагын дагуу, тэдгээрт нийцүүлэн гэрээт ажлыг гүйцэтгэхийг шаардах.

3.2 Захиалагчийн үүрэг:

- 3.2.1 Гэрээт ажил гүйцэтгэхтэй холбоотой аливаа нөхцөл боломжоор хангах, стандарт нэвтрүүлэх ажлын хэсгийг байгуулах ба тэдгээрийг хяналт удирдлагаар хангах.
- 3.2.2 Гүйцэтгэгчээс ирсэн заавар зөвлөгөө, үүрэг даалгаврыг мөрдөж ажиллах.
- 3.2.3 Гүйцэтгэгчийн ажлын хөлсийг гэрээгээр тохирсон хугацаанд саадгүй төлөх.
- 3.2.4 Гүйцэтгэгчийн тавьсан бусад санал, хүсэлтийг тухай бүрд хүлээн авч хариу өгөх, шийдвэрлэх.
- 3.2.5 Стандарт нэвтрүүлэх ажлын төлөвлөгөөг нарийн дагаж мөрдөх, сургалт, уулзалтад ажилтнуудаа бүрэн хамруулах.
- 3.2.6 Гүйцэтгэгчийн тавьсан шаардлага, үүрэг даалгавар, санал хүсэлтийг үл харгалзсаны улмаас ажил гүйцэтгэх явцад үүссэн аливаа эрсдэлийг бүрэн хариуцах.
- 3.2.7 Гүйцэтгэгчийн багш, зөвлөхүүдийг түр байрлах байр, хоол, унаа, ажиллах нөхцөлөөр хангах.
- 3.2.8 Гэрээний хугацаанд гүйцэтгэгчийг ажлаа хийхэд нь шаардлагатай мэдээлэл, холбогдох бичиг баримтыг цаг тухайд нь гаргаж өгөх.
- 3.2.9 Гүйцэтгэгчээс зохион байгуулах төлөвлөгөөт үйл ажиллагаанд, холбогдох ажилтнуудаа бүрэн хамруулах ба бүрэн хамрагдаагүйгээс үүсэх хариуцлагыг өөрөө хүлээх.
- 3.2.10 Гүйцэтгэгчээс өгсөн зөвлөмж болон үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлээгүй эсвэл хангалтгүй биелүүлснээс үүсэх үр дагаварыг захиалагч өөрөө хариуцах.



ДӨРӨВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Гүйцэтгэгчийн эрх:

- 4.1.1 Зөвлөх үйлчилгээний хүрээнд хэрэглэгдэх шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгийг захиалагчаас тухайн үед нь гаргуулан авах.
- 4.1.2 Гэрээт ажлын хөлсөө захиалагчаас гэрээгээр тохирсон хугацаанд нэхэмжилж авах.
- 4.1.3 Сургалт зохион байгуулах өрөө танхим, техник хэрэгслээр хангуулах.
- 4.1.4 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг захиалагчаас шаардах.
- 4.1.5 Гэрээт ажилтай холбоотой аливаа санал хүсэлт гаргах, зайлшгүй үзэх шаардлагатай захиалагчийн ажлын байруудад нэвтрэх боломжоор хангуулах.
- 4.1.6 Захиалагчийн ажилтнуудад үүрэг даалгавар өгөх ба гүйцэтгэлийг шаардах.
- 4.1.7 Захиалагчаас шалтгаалан төлөвлөсөн ажил хугацаандаа хийгдээгүй болон хойшилсон тохиолдолд ажлын хөлсийг багасгахгүй, хойшлуулахгүй гэрээгээр тохирсон хугацаанд авах.

4.2 Гүйцэтгэгчийн үүрэг:

- 4.2.1 Гэрээт ажлыг захиалагчийн тавьсан шаардлагад нийцүүлэн төлөвлөгөөний дагуу чанартай гүйцэтгэх.
- 4.2.2 Гүйцэтгэгчийн багш, зөвлөхүүд нь ХАБЭА-н чиглэлээр мэргэшсэн, тэргүүлэх аудиторууд байх.
- 4.2.3 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллах дадал хэвшил бий болгоход зөвлөн чиглүүлж ажиллах.
- 4.2.4 Захиалагчийн ХЭМАБ-ын МТ-ны дотоод аудиторуудыг бэлтгэж сертификат олгох.
- 4.2.5 Гэрээнд заасан хугацаанд, захиалагчийн шаардлага болон холбогдох хууль, стандартын дагуу гэрээт ажлыг чанартай гүйцэтгэж захиалагчид хүлээлгэн өгөх, тайлагнах.
- 4.2.6 Ажлын явцад алдаа доголдол гарсан тохиолдолд, тухай бүр шуурхай залруулах арга хэмжээ авах.
- 4.2.7 Гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай орчин үеийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, менежментийн арга зүй ашиглах.
- 4.2.8 Гүйцэтгэгчийн багш, зөвлөхүүд нь гэрээт ажлыг гүйцэтгэх явцад ХАБЭА-н дүрэм журам, зааврыг чанд мөрдөж ажиллах ба мөрдөөгүйн улмаас үүсэх үр дагаврыг өөрөө хариуцах.
- 4.2.9 Холбогдох хууль болон гэрээгээр хамгаалагдсан захиалагчийн нууцыг чандлан хадгалах.
- 4.2.10 Захиалагч талаас гүйцэтгэгчийн ажлын талаар гаргасан санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх.

ТАВ. ТАЛУУДЫН ХАРИЛЦАН ХҮЛЭЭХ ҮҮРЭГ

- 5.1 Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гэрээний үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 5.2 Захиалагч нь ажлын төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг гүйцэтгэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 5.3 Энэхүү гэрээтэй холбоотой асуудлаар талууд хурал уулзалт хийн тэмдэглэл үйлдэж,



- шийдвэр гаргаж болох бөгөөд тэмдэглэл, шийдвэр нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 5.4 Гэрээтэй холбоотой аливаа асуудлыг талууд тухай бүр шийдвэрлэж байна.
 - 5.5 Талууд хамтран ажиллах хугацаандаа бие биенийхээ аливаа нууцад хамаарах мэдээллийг бусдад задруулах, нэр хүндэд хууль бусаар халдахыг хориглоно.
 - 5.6 Талуудын аль нэг нь хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүйгээс нөгөө талд учирсан хохирлыг буруутай тал бүрэн хариуцаж арилгах үүрэгтэй.
 - 5.7 Аль нэг тал нь нөгөө талдаа урьдчилан бичгээр мэдэгдэлгүйгээр сайн дураар гэрээнээс татгалзах эрхгүй байна.
 - 5.8 Захиалагчийг төлөөлж гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлыг Хяналтын хэлтсийн дарга Ц.Мандахсайхан утас-88072813 хариуцан ажиллана.
 - 5.9 Гүйцэтгэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Ололт амжилт ХХК-ийн ахлах зөвлөх, тэргүүлэх аудитор Н.Бат-Отгон утас- 88008051 хариуцан ажиллана.

ЗУРГАА. ГЭРЭЭТ АЖЛЫН ҮР ДҮН, ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭХ

- 6.1 Гэрээт ажлын үр дүн, гүйцэтгэлийг зөвлөх үйлчилгээний ерөнхий болон нарийвчилсан төлөвлөгөөний гүйцэтгэл, баталгаажуулалтын аудитын үр дүнгээр тус тус тодорхойлно.
- 6.2 Баталгаажуулалтын аудитын үр дүн нь гэрээний гүйцэтгэлийн эцсийн үнэлгээ байх бөгөөд шалгуур нь ISO 45001:2018 стандартын гэрчилгээ авах нөхцөл байдал болно.
- 6.3 Баталгаажуулалтын аудитаар гэрчилгээ авах нөхцөл байдлыг хангаагүй бол, гүйцэтгэгчээс шалтгаалсан эсэхийг магадлана. Гүйцэтгэгчээс шалтгаалаагүй тохиолдолд захиалагч хариуцлагаа өөрөө хүлээнэ. Энэ тохиолдолд гэрээт ажлын эцсийн үр дүнг ерөнхий болон нарийвчилсан төлөвлөгөөний гүйцэтгэлээр тодорхойлох бөгөөд энэхүү гэрээний 6.2 дахь заалт хүчингүй болно.
- 6.4 Гэрээт ажлын үр дүн, гүйцэтгэлийг дүгнэх үед гүйцэтгэгчээс шалтгаалсан алдаа дутагдал бий болсон бол, захиалагчийн шаардсан хугацаанд гүйцэтгэгч тал алдаа, дутагдлыг үнэ төлбөргүйгээр арилгах үүрэг хүлээнэ.

ДОЛОО. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 7.1 Гэрээний хүчинтэй хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс, 2024 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр хүртэл, нийт 4 сарын хугацаатай байна.
- 7.2 Гэрээний хугацааг сунгах тохиолдолд гэрээнд 1 удаа нэмэлт өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлт нь энэхүү үндсэн гэрээний салшгүй хэсэг болно.
- 7.3 Талууд гэрээний заалтуудыг харилцан зөвшөөрч, гэрээнд гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.
- 7.4 Гэрээг адил хүчинтэй 3 хувь үйлдэж, захиалагч тал 2 хувь, гүйцэтгэгч тал 1 хувийг тус тус хадгална.

НАЙМ. ГЭРЭЭТ АЖЛЫН ХӨЛС, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 8.1 Гэрээт ажлын нийт хөлс нь 38,968,600 (гучин найман сая есөн зуун жаран найман мянга зургаан зуу)-н төгрөг байна.
- 8.2 Захиалагчаас гүйцэтгэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.

4/7

Захиалагч
Гүйцэтгэгч




- 8.3 Гэрээт ажил дуусмагц захиалагч талаас ажлын гүйцэтгэлийг дүгнэн акт үйлдэх бөгөөд акт үйлдсэнээс хойш ажлын 5 хоногт багтаан энэхүү гэрээний 8.1-д заасан гэрээт ажлын нийт хөлсийг гүйцэтгэгчийн "ГОЛОМТ" банкны 1410017413 тоот төгрөгийн дансанд шилжүүлнэ.

ЕС. БУСАД ЗҮЙЛ

- 9.1 Гэрээт ажил дуусах үед гүйцэтгэгч талаас гэрээт ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлэн тайлан боловсруулж захиалагчид танилцуулна.
- 9.2 Гэрээнд тусгагдаагүй нэмэлт ажил үйлчилгээний талаар аль нэг талаас санал гаргасан тохиолдолд тухайн үед харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 9.3 Байгалийн гамшиг, үймээн самуун, дайн, цар тахал, гал түймэр гэх мэт онцгой нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ хэсэгчлэн болон бүрэн биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэх ба талууд харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.
- 9.4 Энэхүү гэрээтэй холбогдон үүссэн аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд нэн түрүүнд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 9.5 Хэрэв тохиролцоонд хүрч чадаагүй бол маргааныг Монгол Улсын хуулийн дагуу харьяа шүүхээр шийдвэрлүүнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:


ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР
Э.МӨНХЖАРГАЛ

/  /

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨЛ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Ө.УДВАЛ

/  /

АЖ АХУЙ, ХАНГАМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
Г.БАТТУЛГА

/  /

ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Ц.МАНДАХСАЙХАН

/  /

ХАНГАМЖИЙН МЭРГЭЖИЛТЭН
М.МОЛОМЖАВ

/  /

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, УС-15-1-1
Утасны дугаар: 77111251
РД: 6021646

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ОЛОЛТ АМЖИЛТ" ХХК-ИЙН
АХЛАХ ЗӨВЛӨХ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
Н.БАГДЛОН

/  /

Хаяг: УБ хот, СБД, 11-р хороо,
Pro-One оффис, 710 тоот.
Утас: 88008051, 88008951
Банкны нэр, данс: Голомт банк, 1410017413

Захиалагч
Гүйцэтгэгч

